

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/60/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>107,493,089.98</u>	<u>107,633,017.98</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	779,092.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	779,092.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	94,634,997.98	92,634,289.98
354	Хангамжийн материал	26,134,999.98	24,134,291.98
35410	Бичиг хэргийн материал	1,481,500.00	91,202.00
35420	Аж ахуйн материал	9,362,449.98	8,489,299.98
35440	Түлш, шатах тослох материал	38,500.00	21,240.00
35470	Бусад хангамжийн материал	15,252,550.00	15,532,550.00
35600	Мал амьтад	68,499,998.00	68,499,998.00
36	НӨӨЦИЙН БАРАА	12,079,000.00	14,998,728.00
36300	Тэжээлийн нөөц	12,079,000.00	14,998,728.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,014,076,950.08</u>	<u>2,065,755,679.24</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,014,076,950.08	2,065,755,679.24
392	Биет хөрөнгө	2,005,952,350.08	2,057,631,079.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,584,096,149.00	1,456,401,395.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(425,368,280.26)	(290,234,387.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,709,986.00	67,859,986.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(72,891,943.23)	(32,351,940.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	286,521,962.30	339,680,309.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(186,069,916.10)	(194,467,787.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,585,224.00	76,430,604.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,188,383.56)	(33,264,264.72)

39209	Зам, гүүрийн байгууламж	496,238,485.00	560,258,486.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(15,899,079.12)	(35,748,618.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	345,206,827.76	331,660,218.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	(173,988,681.71)	(188,592,920.57)
393	Биет бус хөрөнгө	8,124,600.00	8,124,600.00
39301	Програм хангамж	1,333,400.00	1,333,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,333,400.00)	(1,333,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,124,600.00	8,124,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,121,570,040.06</u>	<u>2,173,388,697.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,240,620.00</u>	<u>4,124,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,240,620.00	4,124,500.00
413	Өглөг	3,240,620.00	4,124,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,240,620.00	4,124,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,118,329,420.06</u>	<u>2,169,264,197.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,118,329,420.06	2,169,264,197.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	744,160,007.00	744,160,007.00
51101	Өмч: - төрийн	744,160,007.00	744,160,007.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,201,133,593.26	1,312,499,838.42
51210	Өмнөх үеийн үр дүн	515,474,397.98	1,261,565,061.26
51220	Тайлант үеийн үр дүн	685,659,195.28	50,934,777.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	173,035,819.80	112,604,351.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,121,570,040.06</u>	<u>2,173,388,697.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	465,023,091.89	707,449,850.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,316.89	14,998,728.00

120	Нийтлэг татварын бус орлого	81,316.89	14,998,728.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	81,316.89	14,998,728.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81,316.89	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	14,998,728.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,941,775.00	692,451,122.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,096,275.00	6,867,731.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,184,407.00	4,750,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,711,868.00	2,117,731.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	445,845,500.00	685,583,391.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	445,845,500.00	498,791,400.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	186,791,991.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	570,812,089.61	656,515,072.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	570,812,089.61	656,515,072.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,569,372.72	642,286,712.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,627,839.00	328,176,206.00
210101	Үндсэн цалин	223,752,966.00	212,702,006.00
210102	Нэмэгдэл	75,494,873.00	70,622,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,380,000.00	44,851,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,539,558.00	43,216,286.00
210201	Тэтгэврийн даатгал	27,258,798.00	30,415,622.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,113,438.00	3,202,327.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,862,093.00	2,558,404.00
210204	Ажилгүйдлийн даатгал	664,849.00	639,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,640,380.00	6,400,332.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,274,458.10	20,749,760.00
210301	Гэрэл, цахилгаан	1,490,500.00	1,314,160.00
210302	Түлш, халаалт	20,486,958.10	19,335,600.00
210303	Цэвэр, бохир ус	297,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,519,323.00	44,462,684.00
210401	Бичиг хэрэг	3,273,900.00	3,350,600.00

210402	Тээвэр, шатахуун	21,250,443.00	19,709,086.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,994,980.00	2,011,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,168,750.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	18,222,950.00
2105	Нормативт зардал	2,642,707.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,642,707.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	840,100.00	8,745,500.00
210604	Урсгал засвар	840,100.00	8,745,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,050,838.00	3,657,512.00
210702	Дотоод албан томилолт	4,050,838.00	3,657,512.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,779,800.00	1,239,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	295,000.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,400.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,400.00	84,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	218,900.00	96,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	118,800.00	94,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,294,749.62	191,582,724.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,525,897.00	42,079,463.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,218,852.62	149,003,261.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,242,716.89	14,228,360.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,213,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,213,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,242,716.89	15,060.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,242,716.89	15,060.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(105,788,997.72)	50,934,777.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(105,788,997.72)	50,934,777.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	744,160,007.00	173,035,819.80	515,474,397.98	1,432,670,224.78
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	744,160,007.00	173,035,819.80	515,474,397.98	1,432,670,224.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			685,659,195.28	685,659,195.28
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	744,160,007.00	173,035,819.80	1,201,133,593.26	2,118,329,420.06
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	744,160,007.00	173,035,819.80	1,201,133,593.26	2,118,329,420.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			60,431,468.00	60,431,468.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	744,160,007.00	173,035,819.80	1,261,565,061.26	2,178,760,888.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-60,431,468.00		-60,431,468.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			50,934,777.16	50,934,777.16
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,312,499,838.42	2,169,264,197.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	465,023,091.89	505,659,131.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,316.89	-
120	Нийтлэг татварын бус орлого	81,316.89	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,316.89	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81,316.89	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,941,775.00	505,659,131.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,096,275.00	6,867,731.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,184,407.00	4,750,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,711,868.00	2,117,731.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	445,845,500.00	498,791,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	445,845,500.00	498,791,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	455,603,191.89	491,769,131.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,603,191.89	491,769,131.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,360,475.00	477,540,771.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,542,700.00	326,928,100.00
210101	Үндсэн цалин	223,667,800.00	211,453,900.00
210102	Нэмэгдэл	75,494,900.00	70,622,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,380,000.00	44,851,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,236,500.00	43,685,300.00
210201	Тэтгэврийн даатгал	27,495,500.00	30,208,200.00

210202	Тэтгэмжийн даатгал	3,435,300.00	3,369,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,748,200.00	2,695,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,500.00	673,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,766,000.00	6,738,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,150,000.00	20,732,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,490,500.00	1,314,160.00
210302	Түлш, халаалт	20,362,500.00	19,318,340.00
210303	Цэвэр, бохир ус	297,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,645,133.00	30,662,656.00
210401	Бичиг хэрэг	3,436,800.00	3,244,602.00
210402	Тээвэр, шатахуун	24,183,353.00	21,370,256.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,024,980.00	2,011,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,036,500.00
2105	Нормативт зардал	2,642,707.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,642,707.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,202,800.00	6,293,300.00
210604	Урсгал засвар	3,202,800.00	6,293,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,050,838.00	3,657,512.00
210702	Дотоод албан томилолт	4,050,838.00	3,657,512.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,233,800.00	1,239,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	749,000.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,400.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,400.00	84,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	218,900.00	96,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	118,800.00	94,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,655,997.00	43,885,363.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,105,997.00	43,385,363.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,242,716.89	14,228,360.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,213,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	14,213,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,242,716.89	15,060.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,242,716.89	15,060.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,419,900.00	13,890,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,419,900.00	13,890,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,419,900.00	13,890,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,419,900.00	13,890,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,419,900.00	13,890,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,419,900.00)	(13,890,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498,791,400.00	498,776,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498,791,400.00	498,776,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,578,100.00	484,563,040.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,928,100.00	326,928,100.00
210101	Үндсэн цалин	211,453,900.00	211,453,900.00
210102	Нэмэгдэл	70,622,900.00	70,622,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,851,300.00	44,851,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,685,300.00	43,685,300.00
210201	Тэтгэврийн даатгал	30,208,200.00	30,208,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,369,200.00	3,369,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,695,400.00	2,695,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	673,900.00	673,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,738,600.00	6,738,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,732,500.00	20,732,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,464,500.00	1,314,160.00
210302	Түлш, халаалт	19,168,000.00	19,318,340.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,012,000.00	32,012,000.00
210401	Бичиг хэрэг	3,267,200.00	3,244,602.00
210402	Тээвэр, шатахуун	20,588,300.00	20,564,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,905,000.00	1,951,298.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,251,500.00	6,251,500.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,293,300.00	6,293,300.00
210604	Урсгал засвар	6,293,300.00	6,293,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,242,200.00	3,242,200.00
210702	Дотоод албан томилолт	3,242,200.00	3,242,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,254,100.00	1,239,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	84,800.00	84,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,700.00	96,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	398,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,000.00	94,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,973,600.00	49,973,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,473,600.00	49,473,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,213,300.00	14,213,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,213,300.00	14,213,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,213,300.00	14,213,300.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	498,791,400.00	498,776,340.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	498,791,400.00	498,776,340.00
132001	Орон нутгийн төсвөөс	498,791,400.00	498,776,340.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	34.00
620001	Удирдах ажилтан	15.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	8.00

620004	Гэрээт ажилтан	7.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.00	34.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	14.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,867,731.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,867,731.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,867,731.00
2104	Хангамж, бараа материалын зардал	865,656.00
210402	Тээвэр, шатахуун	805,656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00
2107	Томилолт, зочны зардал	415,312.00
210702	Дотоод албан томилолт	415,312.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,586,763.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,586,763.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,867,731.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,867,731.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,117,731.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Дэлүүн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 3/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажил, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд шалгалт хийгээгүй байна.

ЗДТГ нь дотоод хяналтын нэгжтэй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 570.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136.7 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	779.1	-	(779.1)
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	94,635.0	92,634.3	(2,000.7)
Үндсэн хөрөнгө	2,014.076.9	2,065.755.7	51,678.7
Нийт хөрөнгө	2,121.570.0	2,173.388.7	51,818.6

Өр төлбөр	3,240.6	4,124.5	883.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,118,329.4	2,169,264.2	50,934.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,121,570.0</u>	<u>2,173,388.7</u>	<u>51,818.6</u>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансанд оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 0.8 сая төгрөгийн авлагатай байсныг барагдуулж оны эцэст авлагагүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92.6 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 15.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хандиваар, 81.0 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч үйл ажиллагаандаа 69.8 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 7.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийг Эрүүл мэнд төвд шилжүүлж, 18.2 сая төгрөгийн бараа материалыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор акталж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,065.8 сая төгрөг болж 51.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 13.9 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 186.8 сая буюу нийт 200.7 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ ын огтоолоор 99.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд, хогшил, замыг акталж, үндсэн хөрөнгөнд 149.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэнд 3.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан нь 4.1 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тээвэр шатахууны өглөгийг 1.6 сая төгрөгөөр бууруулж, ургал засварт шинээр 2.5 сая төгрөгийг өглөг үүсгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,169.2 сая төгрөг болж 50.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 50.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 707.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 242.4 сая төгрөгөөр буюу 52.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт болон хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 85.7 сая төгрөгөөр буюу 15.1 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант онд хөрөнгө акталсантай холбоотой, дахин үнэлгээний зөрүүгээр 60.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 455.8 сая төгрөг, тодотгосон төсөв 498.8 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 43.0 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.

Дэлүүн сумын ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 15 дугаар тогтоолоор орон нутгийн орлогын давж биелэгдсэн орлогоос ЗДТГ-т 43.0 сая төгрөгийг хуваарилаж баталсан байна.

Цалин, НДШ-ийн зардлыг 11.8 сая, томилолтын зардлыг 0.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжыг 0.1 сая, нийт 12.2 сая төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 2.0 сая, хангамж, бараа материалын зардлыг 16.5 сая, эд, хогшил, урсгал засварын зардлыг 5.0 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 31.7 сая, нийт 55.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 498.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 498.8 сая төгрөгийг зарцуулж, 0.01 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 0.01 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 65.5 хувийг цалин, 8.9 хувийг НДШ-ийн зардал, 4.1 хувийг тогтмол зардал, 6.4 хувийг хангамж бараа материалын зардал, 10 хувийг бараа үйлчилгээний зардал, 5.1 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 4.8 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 2.1 сая төгрөгийн орлого хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 0.8 сая, томилолтын зардалд 0.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 5.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлээр нийтдээ 498.7 сая төгрөгийн төсөв зарцуулснаас байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардал 93.2 сая төгрөгийн төсвийн 10 хувиар 9.3 сая төгрөгөөр

хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Дэлүүн Засаг даргын тамгын газрын 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 117 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.2 сая төгрөгийн 1 худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг оруулаагүй, 4.1 сая төгрөгийн өр үүсгэсэн 2 шийдвэрийг оруулаагүй, тайлант оны шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 87.5 хувьтай байгаа ба өмнөх онд шилэн данстай холбоотой зөвлөмж аваагүй байгаа тул тайлант онд илэрсэн зөрчлийн дүнгээр зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шуудан холбоо, гэрэл цахилгаан, томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд шилжүүлсэн нийт 13.2 сая төгрөгийн гүйлгээг тооцоо үүсгэхгүйгээр, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөгдсөн. Зөвлөмжийн биелэлтийг Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 3/83 тоот албан бичигээр ирүүлсэн байна. Тайлант оны байдлаар хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчлийг арилгасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 10.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 9.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлээр нийтдээ 498.7 сая төгрөгийн төсөв зарцуулснаас байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардал 93.2 сая төгрөгийн төсвийн 10 хувиар 9.3 сая төгрөгөөр хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасны дагуу хэмнэж зарцуулаагүй 9.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.2 сая төгрөгийн 1 худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг оруулаагүй, 4.1 сая төгрөгийн өр үүсгэсэн 2 шийдвэрийг оруулаагүй, тайлант оны шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 87.5 хувьтай байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг бүрэн байршуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх ;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар	2	19.6					1	9.3	1	10.3